

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2025 оны 05 сарын 12-ны өдөр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуульд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл:	Санал: Нэмэх, Өөрчлөх, Хасах	Тайлбар:
17.2.Хорих байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 17.2.1.хорих ялыг албадан эдлүүлэх; 17.2.2.хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх; 17.2.3.хоригдлыг нийгэмшүүлэх; 17.2.4.хоригдлыг хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, эрхэлсэн үйлдвэрийн чиглэлээр хоригдолд дадлага олгох; 17.2.5.хоригдолд албан, албан бус хэлбэрээр боловсрол олгох; 17.2.6.хоригдлын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх; 17.2.7.гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгах, хорих байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;	Нэмэх: 17.2.Хорих байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 17.2.10.хоригдлын сэтгэл зүйг хамгаалах, сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгох;	17.2.10.хоригдлын сэтгэл зүйг хамгаалах, сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгох; Энэхүү заалтыг оруулах нь маш чухал юм. Хэдийгээр хоригдолд нийгмийн дунд сөрөг хандлагыг ихээр гаргадаг боловч тэдгээр хүмүүс нь нийгэмд дахин нэгдэх тул тэдний сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарах нь ач холбогдол өндөртэй юм. Хоригдлын хүмүүжил, зан төлөвт нөлөөлөх олон хүчин зүйлсийн нэг нь түүний сэтгэл зүйн байдал юм. Сэтгэл зүйн үйлчилгээ, тусламжийг сэтгэл зүйн сорилго, тестийн тусламжтайгаар илрүүлснээр хүмүүжлийн үйл явцад сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсийг урьдчилан үнэлэх боломжийг олгох ач холбогдолтой байна. Сэтгэл зүйн үнэлгээний ач холбогдол нь хоригдлын сэтгэл зүйн байдал, хэрэгцээ, хандлагыг тодорхойлж, тэдэнд

17.2.8.хоригдлыг суллахад бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлэх; 17.2.9.хуульд заасан бусад чиг үүрэг;		зориулсан хүмүүжлийн хөтөлбөрийг зохион байгуулахад тусална. Мөн энэ нь хоригдлын сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ингэснээр хоригдлын хүмүүжлийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд тусална. Энэ нь хоригдлын сэтгэл зүйн байдал, хэрэгцээг харгалзан ямар хөтөлбөрөөр, хэрхэн нийгэмшүүлэх арга замыг оновчтой олоход тустай байдаг тул энэхүү заалтыг оруулах саналтай байна.
--	--	---

---oOo---